



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/249

Хэрлэн сум

Уулзалт зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн удирдлагууд төрийн бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, цаг үеийн ажлын талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэх, тэдний санал хүсэлтийг сонсох уулзалт зохион байгуулахад 2,803,500 (хоёр сая найман зуун гурван мянга таван зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
... дугаар сарын ... өдрийн .....  
... дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Томилолт	11 хүн 3 хоног	26,500*33	874,500
2	Шатахуун- АИ-92	800 (2 машин *320 л)	2,520	806,400
3	Шатахуун /Дизель /	800 (1машин *160 л)	3380	540,800
4	Ахмад настан, малчдад хүндэтгэл үзүүлэх			581,800
Дүн				2,803,500